



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/446

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 42 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 20,489,998.40 /хорин сая дөрвөн зуун наян есөн мянга есөн зуун ерэн найман төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг /Д.Цэрэндолгор/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус 9 нэр төрлийн 20,489,998.40 /хорин сая дөрвөн зуун наян есөн мянга есөн зуун ерэн найман төгрөг 40 мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг /Д.Цэрэндолгор/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 08 ны өдрийн
А/1446 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 42 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж													
1	Хөлдөөгч	8	ш	1	352900.0	352 900.00	352 900.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
2	Хөлдөөгч	13	ш	1	390720.0	390 720.00	390 720.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
3	LCD проектор	8	ш	1	1143994.5	1 143 994.50	1 143 994.50	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
4	Компьютер / Суурин/	8	ш	3	931656.0	2 794 968.00	2 794 968.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						4 682 582.50	4 682 582.50	-					
Тавилга, эд хогшил													
5	Хивсэнцэр	12	м	16	22500.0	360 000.00	360 000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
6	Дрож	12	м	12	28000.0	336 000.00	336 000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
7	Хээтэй дрож	12	м	15	24000.0	360 000.00	360 000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
8	Хангал дрож	12	м	12	19231.0	232 695.10	232 695.10	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
Тавилга, эд хогшлын дүн						1 288 695.10	1 288 695.10	-					
Барилга байгууламж													
9	Бетон суурьтай төмөр хашаа	14	ком	1	14518721	14 518 720.80	1 209 893.37	13 308 827.43	Хашаа шинээр барисан. Ашиглалтын хугацаа дууссан боловч 2018 онд дахин үнэлсэн.	актлах	устгах	татах	татах
Барилга байгууламжийн дүн						14 518 720.80	1 209 893.37	13 308 827.43					
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						20 489 998.40	7 181 170.97	13 308 827.43					
Үүнээс Татан төвлөрүүлэх хөрөнгө						20 489 998	7 181 171	13 308 827					
Актлах хөрөнгө						-	-	-					